



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 11 сарын 25 өдөр

Дугаар А/419

Мөрөн сум

Газар эзэмшүүлэх эрх олгох дуудлага  
худалдааг хүчингүй болгох

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.11, 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, 33 дугаар зүйлийн 33.1.2, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3, 15 дугаар зүйлийн 3, Захиргааны ерөнхий хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.3, 4.2.5, 24 дүгээр зүйлийн 24.1, 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1 дэх заалт, Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолоор батлагдсан “Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журам”-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Нэр бүхий иргэний гаргасан гомдлын дагуу судлан үзэхэд аймгийн Засаг даргын 2022 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн А/210 дугаар “Ажлын хэсэг байгуулах тухай” захирамжаар томилогдсон ажлын хэсэг маргаан бүхий 2022 оны 06 дугаар сарын 27-ны өдөр дуудлага худалдааг зохион байгуулахдаа уг дуудлага худалдаа явуулахаар товлосон өдрөөс 30-аас доошгүй хоногийн өмнө олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон нутгийн захиргааны байгууллагын цахим хуудсаар тус дуудлага худалдааг зарлан мэдээлээгүй нь аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын албан бичиг, холбогдох баримтаар тогтоогдсон тул аймгийн Засаг даргын 2022 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн А/172 дугаар захирамжийн хавсралтын 1 дэх хэсгийг хүчингүй болгосугай.

2. Захиргааны актыг ажлын 3 хоногийн дотор эрх ашиг, сонирхол хөндөгдөж буй этгээдэд мэдэгдэж, баримтжуулсан захиргааны актыг хувийн хэрэгт бүрдүүлэлт хийж ажиллахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Б.Ганзориг) -д үүрэг болгосугай.

3. Аймгийн Засаг даргын захирамжийг эс зөвшөөрвөл захирамжийг мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор шүүхэд гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

4. Энэхүү захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Хууль, эрх зүйн хэлтэс (М.Алтаншагай)-д даалгасугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН

6710011000